

МОНГОЛ УЛС ДАХЬ МОНГОЛЫН СУДЛАЛЫН ТУХАЙ ЦУВАА ЦАГИЙН ҮҮДНЭЭС  
ТОВЧ ПНИЛЦУУЛАХ, ХОЁРТ, ТУС САЛБАРЫН ХӨГЖИЛД ДУГАГДАЖ БАЙГАА АСУУДЛЫГ ӨӨРИЙН ЗҮГЭЭС ХАРАХ  
ЗОРИЛТЫГ АГУУЛАХ БОЛНО.

Ш.Чоймаа<sup>1</sup>

Тус илтгэл нь нэгд, Монгол Улс дахь Монголын судлалын тухай цуваа цагийн үүднээс товч пнилцуулах, хоёрт, тус салбарын хөгжилд дутагдаж байгаа асуудлыг өөрийн зүгээс харах зорилтыг агуулах болно.

1. Монголын судлал бол аливаа улс үндэстний талаарх судалгааны адилаар өргөн хүрээ хамаргнийг та бид сайтар мэдэх билээ. Тэрхүү цараа нь дотооддоо монголчуудын болоод монгол туургатны нийгэм, түүх, хэл, бичиг, соёл, зан суртал, эдийн засаг, хууль зүй, аж ахуй, газар нутагээрэг оршихуйн бүхий л тал багтахын дээр, гадагш харилцаж ирсэн хил залгаа улсуудаас эхлээд дэлхийн хэмжээнд тэлдэг учир олон орны эрдэмтэн судлаачдын судалгаа шинжилгээний үр шимээр боссон юм. Харин, түүний шинжлэх ухааны жинхэнэ салбар болсныг Оросын I Петр ааны “нээлттэй бодлого”-ын үр дүнтэй хөлбөж, хөлданд гаралтай Я. Шимидгийн 1830-аад оны үед нийтлүүлсэн “Монгол хэлний зүй”, польш гаралтай О. Ковалевский, оросын А. Бобреников нарын зохих бүтээлийг эх суурь болгон үзэх нь буй.

Гвч уг эхийг нь өнөөгийн мэдлэгийн хирээр мөшгөвөл, Христусын тооллын өмнөх үеийн эртний Хятадын түүхэн тэмдэглэлүүд рүү хүрч очих агаад дэлгэрэл нь илэрхийгээр Монголын Эзэнтгүрний үед хамаатай. Хубилай хааны дэргэд 17 жил суусан Марко Поло (1254-1324)-гийн тэмдэглэл, Рашид ал Дин, Жувайни нарын сурвалжууд, Хятадын Мин улсын эхэн үеийн “Монолын нууц товчоон” тэргүүтэй тухайн цагийн бүтээлүүдийн залгамж хэдэн зууны дараа ч үргэжилсээр ирсэн бөгөөд Европ зүгт гарсан монгол хэлний хамгийн анхны хэл зүй болох Францын Мелчиседик Тэвэно (1620-1692)-ын “Монгол хэлний хэлзүй” (1672), мөн Францын Абел Ремюза (1788-1832)-гийн “Татааруудын хэлний судлагаа буюу тэмдэглэл” (1820) орно. Ийнхүү үзвэл, монголын судлалын түүхийг их л эртнээс эхлүүлбэл зохино. Өрнө, дорны ийм их далайцаас Монголын хэмээн тодотгогдох нэгэн хэсгийн талаар тухайлан хэлэлцвэл, Монгол улс дахь Монголын судлалын зохион байгуулалттайгаар эхэлсэн хөгжлийг Судар бичгийн хүрэээн, Олон улсын монгол судлалын холбоо, Монгол улсын их сургууль гэсэн гурван гол байгууллагын үйл ажиллагааны үндсэн дээр харах боломжтой юм. Үүнд,

Сдар Бичгийн Хүрээлэн бол өнөөгийн Шинжлэх Ухааны Академийн төдийгүй Монголын судлалын эх үүтгэл болсон ууган байгууллага болно. Анх байгуулагдсан баримтыг сонирцуулбаас,

Оноо өргөгдсөний 11 оны 10 сарын 1-ний өдөр Засгийн газрын хуралдаж зөвлөлдөн

1. Монгол Улсын Их Сургууль

### Ш.Чоймаа

тогтоосон 24 дүгээр хурлын бичигт: “Туравдугаар зүйл. Манай засгийн газраас томилон гаргасан эрдэмтэн түшмэл Жамсранов, сайд гүн Жамъян, гүн Дашням, түшмэл Бат-Очир нараас Монголын Нийслэл хүрээнд Судар бичгийн хүрээлэн байгуулж, гадаад олон улсын зүйл бүрийн ухааны ба улс төрд хэрэглэгдэх судар бичгийн чухал хэрэгтэйг нь монгол үсгээр орчуулж авах ба уул монголын хэлээр зохиож дэлгэрүүлэн монголын эрдэм боловсролд тустай болох арван таван зүйлийн дүрэм хэмжээ заан бичиж тогтоолгохыг эрж ирүүлснийг хэлэлцээд энэ зүйлийн номын хүрээлэнг нээн байгуулахаар төлөвлөсөн дүрэм хэмжээ маш зүйтэй болсон тул ёсоор болгон баталснаас гадна, эрхлэх сайдыг засгийн газраас сонгон томилж айлтгаад тогтоолох ба Судар бичгийн хүрээлэнгийн зүйлд энэ удаа хэрэглэх гурван мянган ланг засгийн газраас сангийн яамнаа хуудас явуулж тавин олгуулахаар тогтов” хэмээн дурджээ.

Ийнхүү, тус хүрээлэн Санкт Петербургийн академид ажиллаж, Богд хаант Монгол улсын үед Монголд ирж, орчин үеийн шинжлэх ухааны эх үүсвэрийг тавих, соён гэгээрүүлэх үйлд хүчин зүтгэж байсан профессор Жамсранов буюу Жамсрангийн Цэвээн, 1921 оны 11-р сарын 19-ний өдөр Засгийн газрын шийдвэрээр хүрээлэнгийн даргаар тохоон томилогдсон гүн Жамъян, манжич Бат-Очир нарын бичгийн хүмүүсийн санаачлагаар байгуулсан аж.

Тусгаар тогтносон Монгол улсын соёл, гэгээрэл, эрдэм шинжилгээний анхны суурь болох энэ байгууллагыг тэргүүлсэн Жамъян гуай тэр даруйдаа өөрийн сууж байсан орос маягийн жижиг байшингаа суллаж Судар бичгийн хүрээлэнг оруулж хэрэг шийтгэн эхэлснээ 1921 оны 11-р сарын 21-нд нийтэд мэдэгдсэн байна.

Хүрээлэн бүрэлдэхүүнээ эхнээсээ л эрдэмтэн сэхээтэн хүмүүст түшиглэсний зэрэгцээ олон улсын эрдэмтдийг хүндэт болон жинхэнэ гишүүнээр сонгон холбоотой ажиллаж байв. Үүнд жишээ нь, хятадач Дандаа, төвдөч Шагж, Зава лам хэмээн алдаршсан Ишдамдин нар болоод Зөвлөлт Орос улсын монголч эрдэмтэн Козлов, Владимирцов, Францын Пеллиор, Цюльшийн Котвич нарыг дурдаж болно. Хамтын ажиллагааны бас нэгэн жишээнд Германы монголч эрдэмтэн Эрих Хайнишийн “Эрдэнийн товч”-ийг нэрлэж болох юм. 1955 онд Берлин хотноо хэвлэгдсэн уг бүтээлийн өмнөх үгэнд өгүүлсэнчлэн, монгол сурвалжийн энэхүү судалгаа 1928 оны зун Монголын Засгийн газар Эрих Хайнишийг урин ирүүлж, түүнд номын санд хадгалагдаж байсан Саган Сэцэний “Эрдэнийн товч”-ийн маш сайн 2 гар бичмэл эхийн гэрэл зургийн хуулбарыг бэлэглэснээр, 27 жилийн дараа нийтийн хүртээл болсон түүхтэй.

Бүтцийн хувьд, Дуун ухааны тасаг (Хэл бичгийн ухааны), Түүхийн тасаг, Газар зүйн кабинеттай байв. Хүрээлэнгийн судалгааны хөтөлбөрт монголчуудын хэл бичиг, түүх, соёл, зан заншлыг судлах, холбогдох судар ном, бичиг данс, түүх соёлын дурсгалыг зохион байгуулалттайгаар цуглуулах, эрдэм шинжилгээний зохиол бүтээлийг орчуулах зэрэг ажлыг тусгаж байжээ. Үүний үр дүнд үндэсний эрдэмтдийн олон арван бүтээл, монгол хэл, түүх, эдийн засаг, хууль гэх мэт олон салбараар гарснаас нэгийг онцлоход Ишдамдины төвд хэлээр бичсэн монголын түүхийн “Алтан дэвгэр” нэрт зохиол судалгааны үнэ цэнт бүтээл хэмээн үнэлэгддэг.

1920-1930 оны үед Монголын боловсрол, шинжлэх ухааны салбарт засгаас анхаарсан явдал хүрээлэнгийн ажилд түлхэц болж өгөв. Үүнд дутагдаж байсан боловсон хүчнийг бэлтгэхэд онцгой анхаарч, Зөвлөлт холбоот улс, Франц, Герман зэрэг оронд окутан явуулж сургасан нь хожмын эрдэмтэд, монгол судлаачид болсон билээ. Нийгмийн ухааны салбараас гадна монголын физик, газар зүйн судалгааг Зөвлөлт холбоот улсын мэргэжилтнүүдтэй хамтран хийж, монгол орны хэдэн зүйл газрын зургийг хэвлэн гаргах, ургамал, амьтан, хөрс шороо, мал аж ахуй, бэлчээр тариалан зэргийг судлах талаар хийсэн ажлууд Монголын судлалыг байгалын ухаан руу өргөжүүлж өгснийг тэмдэглэх хэрэгтэй. Ардын хувьсгалын дараа 1930 он хүртэл манай

### Ш.Чоймаа

улс төрийн байдал тогтвортой байж, орчин үеийн шинжлэх ухааны олон салбарын эх үүсвэр тавигдаж эхэлсэн учир шинэ шинэ ухагдахуун ойлголтыг тэмдэглэсэн нэр томъёог цэгцлэн боловсруулах гэх мэт олон шаардлагаар монголын судлал нарийн мэргэжлийн бусад салбарын хамт бие биеэ тэтгэн хөгжиж байв.

Удалгүй гарсан өмнөх улс төрийн аясыг даган Судар бичгийн хүрээлэнгийн судалгааны чиг хандлага ч өөрчлөгджээ. 1930 оны 2 дугаар сарын 5-ны өдрийн Улсын бага хурлын тэргүүлэгчдийн шийдвэрээр тус хүрээлэнг Бүгд Найрамдах Монгол Ард Улсын Шинжлэх ухааны хүрээлэн болгов. 1946 он гэхэд түүх, газар зүй, хэл бичиг, номын сан, улсын архив, газар тариалан, мал аж ахуйн кабинет, хувьсгалын музей, Сүхбаатарын музей, Марксизм, Ленинизмын кабинет зэрэг салбартай болсон байна. Бүгд найрамдах монгол ард улсын Ардын их хурлын тэргүүлэгчдийн 1961 оны 5-р сарын 1-ний өдрийн зарлигаар Шинжлэх ухааны хүрээлэнг Шинжлэх Ухааны Академи болгон өөрчилжээ. Мөн оны 5 сарын 24-нд Монголын эрдэмтдийн хурал болж академич, сурвалжлагч гишүүд, түүнчлэн академийн тэргүүлэгчдийг сонгосон байна. Академийн ерөнхийлөгчөөр түүхийн ухааны доктор, нийгмийн зүтгэлтэн Б. Ширэндэвийг сонгосон нь монголын судлалын нэргэй эрдэмтэн байснаар олон салбарын судалгаа шинжилгээ, бүтээл туурвилд чухал нөлөөлсөн гэж хэлж болно. Тийм учраас түүний мэндэлсний зуун жилийн ойг энэ онд тэмдэглэж, олон улсын эрдэм шинжилгээний хурал хийсэн билээ.

Ерөнхийд нь, Судар бичгийн хүрээлэнгийн гол гавьяаг дүгнэхэд, нэгд, монголын судлалын шинжлэх ухааны үндэстэй хөгжүүлэх эхлэлийг тавьсан. Хоёрт, монголын судлалын гадаадын нэргэй эрдэмтэдтэй холбоо харилцаа тогтоож, тэдний заавар зөвлөгөөг авч байсан. Гуравт, ховор хуучин ном судар, гар бичмэл, бичиг дансыг төлөвлөгөөтэйгөөр эрэн сурвалжилж, цуглуулан цэгцэлж авсан. Дөрөвдүгээрт, гадаад хэлээрх монголын судлалын гол эх сурвалжуудыг орчуулж эхэлсэн. Ганц жишээ дурдахад, Юань улсын судрын 210 дэвтрийг Дандаа буюу Дэмчигдорж бээр хятад хэлнээс бүрнээр орчуулсан нь одоо Монгол улсын Үндэсний номын санд хадгалагдаж байна. Тавдугаарт, Судар бичгийн хүрээлэнгийн цуглуулсан хэрэглэгдэхүүнийг ангилан эмхлэх үед Улсын архивыг байгуулах хэрэгтэй болж 1927 онд Судар бичгийн хүрээлэнгийн дэргэд тус байгууллагыг буй болгожээ. Зургадугаарт, тухайн үеийн анхны сурагч оюутан болон өргөн олон нийтэд монголчуудын түүх, хэл, соёл, утга зохиолын талаар тогтолцоотой мэдээллийг хүргэж, цөөнгүй сурах бичгээр хангаж байсан. Долдугаарт, эрдэмтэн мэргэдийг үзэл суртлаар хэмжүүр тавилгүй тус хүрээлэнгийн ажилд татан оролцуулж байсан нь тун сайшаалтай хэрэг байсан юм. Түүнчлэн Судар бичгийн хүрээлэнгийн үеэс судалгаа, шинжилгээгээ эхэлсэн академич Б. Ринчен, академич Ц. Дамдинсүрэн, академич Ш. Лувсанвандан, академич Ш. Нацагдорж нарын зэрэг дэлхийд нэрд гарсан эрдэмтэд төрөн гарч, тэдний дэг сургуулиар олон үеийнхэн бэлтгэгдсэн нь Монгол улсад монголын судлал хөгжин дэлгэрэхэд онцгой хувь нэмэр болсон юм. Цаг цагийн улс төрийн ааш араншингаар эдгээр эрдэмтдийг үндэсний үзэлтэн, хуучныг баримтлагч гэх мэтээр буруутгаж байсан боловч тэд судалгаа шинжилгээнийхээ чиг хандлагыг огтхон ч өөрчлөлгүй, харин ч улам эрчимжүүлж явсныг бахархан тэмдэглэвээс зохилтой.

Олон улсын монгол судлалын холбоо. Дээр нэр дурдсан эрдэмтэд гол санаачлагыг гаргаж, олон улсын монгол хэл бичгийн эрдэмтний анхдугаар их хурлыг 1959 онд Улаанбаатар хотод хийсэн нь Монгол улсын Монгол судлалд тун жинтэй хувь нэмэр болсон юм. Энэ хуралд 14 орны 42 эрдэмтэн оролцож, 40 гаруй илтгэл хэлэлцсэн ба хуралд Английн Ч. Баудэн, Хятадын Вэн Ду-цзын, Японы Г. Абэмацу, Ш. Озава, Финляндын Пенги Алто, Оросын Ю. Н. Рерих, Г.Д.Санжеев, Энэтхэгийн Рагу Вира, Монголын Ц. Дамдинсүрэн, Б. Ринчен, Ш. Лувсанвандан нарын эрдэмтэд оролцож, олон орны монголч эрдэмтдийн хамтын ажиллагаа зохион байгуулалтад орохын эх суурийг тавьсан түүхтэй. Энэ хуралд оролцсон Рагу Вира

### Ш.Чоймаа

“Монгол орны нийслэлд монголч эрдэмтэд хуран цугларах завшаан олдсон явдал бол тун чухал зүйл мөн. Японоос Канад, Улаан-үдээс Дели хүртэлх удам нутгийг хамарсан олон орны төлөөлөгчид бие биетэйгээ нүүр учран эрдэм мэдлэгээ баяжуулахын тулд энд хуран цуглараад байна” хэмээн илтгэлийнхээ эхэнд хэлсэн нь чухамхүү энэ хурлыг үнэлж дүгнэсэн бодит үнэн юм.

1970 онд хуралдсан Олон улсын Монголч эрдэмтний (ОУМЭ) II их хурал Монголын судлал Монгол улсад тогтолцоотой, зохион байгуулалттай хөгжиж дэлхийн монголч эрдэмтэдтэй байнгын хэлхээ холбоотой ажиллах боломжийг хангахад онцгой үүрэг гүйцэтгэсэн. Тус хурлаар одоогийн Монгол судлалын холбооны эх суурь болсон “Олон улсын монголч эрдэмтний байнгын хороо”-г буй болгосон юм. Тэрхүү байнгын хорооны үндсэн дээр 1987 онд хуралдсан Олон улсын монголч эрдэмтний V их хурлаас олон оронд монгол судлалыг төлөөлсөн 48 эрдэмтний бүрэлдэхүүнтэй “Олон улсын монгол судлалын холбоо”-г өргөтгөн, гүйцэтгэх хороо 11 эрдэмтний бүрэлдэхүүнтэй, “Олон улсын монгол судлалын холбооны нарийн бичгийн дарга нарын газар”-ыг тус тус зохион байгуулжээ. Анхны ерөнхийлөгчөөр Америкийн монголч эрдэмтэн О. Латтимор, дэд ерөнхийлөгчөөр профессор Ч. Бауден, профессор Чингэлтэй, профессор В. Хайссиг, профессор Ш. Нацагдорж, профессор Ш. Озава, профессор В. Солнцев, профессор Х. Фитце нарыг, ерөнхий нарийн бичгийн даргаар профессор Ш. Бираг тус тус сонгосон байна. Латиморын дараагаар холбооны ерөнхийлөгчөөр японы нэрт монголч эрдэмтэн Ш. Озава идэвхи зүтгэлтэй ажиллаж, Монгол улсад төвтэй тус холбооны байнгын ажиллагааг Ш. Бира олон жил удирдлаа.

Нэгдсэн үндэсний байгууллагын Шинжлэх ухаан соёл боловсролын байгууллага (UNESCO)-ын “С” зэрэглэлтэй, засгийн газрын бус олон улсын шинжлэх ухааны байгууллага энэхүү холбоо нь өнөө хүртэл олон улсын монголч эрдэмтдийн их хурлыг зохион байгуулж, “Монголын судлал” хэмээх судалгааны цуврал, “Монгол судлалын мэдээлэл” сэтгүүлийг тогтмол гаргаж, дэлхийн 30 гаруй улсуудад ажиллаж байгаа монгол судлалын үндэсний төв, нийгэмлэгийн үйл ажиллагааг зангидаж ажилладаг. 1997 онд болсон ОУМЭ VII их хурлын үед, холбоо байгуулагдсаны 10 жилийн ойн ёслолын нээлтийн хурал дээр академич Ш. Бира илтгэлээс үйл ажиллагааны түүхэн явцыг харж болно.<sup>2</sup> Тэрбээр “Олон улсын монгол судлалын холбоо” нь шинжлэх ухаан, зохион байгуулалтын хувьд бэхжин төлөвшилөө. Одоогийн байдлаар ОУМСХ-нд дэлхийн 30 гаруй улс орны 300 гаруй монголч эрдэмтэн, байгууллага гишүүнээр элсээд байна. Монгол судлалыг аль нэг хэмжээгээр хөгжүүлж буй улс орноос тус Холбоотой харилцаа холбоогүй эрдэмтэн, байгууллага байхгүй гэж хэлж болно. Өнгөрсөн хугацаанд олон улсын чанартай хэд хэдэн томоохон арга хэмжээг зохион явуулав. Үүнд, Олон улсын залуу монголч эрдэмтдийн зуны сургууль (1989), Монголын нууц товчооны 750 жилийн ойд зориулсан Олон улсын бага хурал (1990), Монгол, Солонгосын эрдэмтдийн анхдугаар симпозиум (1991), Монгол, Энэтхэгийн эрдэмтдийн 2 удаагийн симпозиум (1989, 1991), Шинэ Дели дэх Жавхарлал Неругийн их сургуультай хамтран зохион явуулсан Олон улсын монгол судлалын бага хурал (1995), Монголын анхдугаар богд Занабазарын мэндэлсний 360 жилийн ойд зориулсан Олон улсын бага хурал (1995) зэргийг дурдвасаас зохино. Өнгөрсөн 10 жилд ОУМСХ өөрийн тогтмол хэвлэлтэй болж, “Монголика” цувралын 8 дугаар, “Монгол судлал” сэтгүүлийн 19 дугаарыг тус тус хэвлэн гаргасан. Дэлхийн монгол судлалын шилдэг бүтээлүүдийг монголчуудад танилцуулах зорилгоор “Дэлхийн монгол судлалын дээжис” хэмээх цувралыг гаргах болсон бөгөөд 1996 оны анхны дугаарт нэрт монголч эрдэмтэн Б. Владимирцовын “Чингис хаан” зохиолыг монголоор орчуулан нийтлүүлэв. Төв азийн иргэншлийн түүхийг зохион бичих ЮНЕСКО-гийн олон улсын төсөлд оролцож, одоогоор “Төв азийн иргэншлийн түүх” 6 ботийн эхний 3 боть хэвлэгдсэн гарсан. Холбооны нарийн бичгийн дарга нарын газраас явуулж ирсэн

2. Ш. Бира, Монголын түүх, соёл, түүх бичлэгийн судалгаа, III, Улаанбаатар, 2001, 466-472-р тал.

### Ш.Чоймаа

нэг томоохон ажил бол “Олон улсын монгол судлалын ном зүй”, “Дэлхийн монголч эрдэмтдийн лавлах” хэмээх урт хугацааны төсөл болно. Холбооны нарийн бичгийн дарга нарын газарт монгол судлалын мэргэжсэн номын сангийн эхлэлийг тавих зорилгоор бид 3000 шахам номын цуглуулгыг буй болгоод байна” гэжээ. Энд монголын судлал хэрхэн хөгжсөнийг товч тодорхой өгүүлжээ.

2011 оны олон улсын монголч эрдэмтдийн X их хурлаас, холбооны ерөнхийлөгчөөр ХБНГУ-ын монголч эрдэмтэн профессор К.Сагастер, ерөнхий нарийн бичгийн даргаар академич Д.Төмөртоогоо сонгогдон ажиллаж байна.

Дүгнэн үзвээс, Олон улсын монгол хэл бичгийн эрдэмтдийн анхдугаар их хурлаас хойш дэлхийн монгол судлалын байгууллага, монголч эрдэмтдийн харилцаа, хамтын ажиллагаа мэдэгдэхүйц эрчимжин, олон улсын монголч эрдэмтдийн уулзалт, цуглаан тогтмолжиж, монголын тухай шинжлэх ухаан ч гүнзгийрэн хөгжиж, зөвхөн монгол хэл бичиг төдийгүй, монголын түүх, соёл, иргэншил болон улс төр судлал, эдийн засаг, гүн ухаан, хууль цааз зэрэг нийгмийн шинжлэх ухааны бүх салбарыг хамрах болжээ. Түүнчлэн тусгаар тогтносон Монгол улсад “Олон улсын монгол судлалын холбоо”-ны төв нь оршиж, идэвхитэй ажиллах нь дэлхийн монгол судлалд ч, Монгол улсын үндэсний эрх ашигт ч бүрэн нийцэх зүйл гэдгийг тэмдэглэх нь зүйтэй.

Монгол улсын их сургууль. Дэлхийн II дайны гал ид дүрэлзэж байсан “1942 оны 10-р сарын 5-нд Монгол улсын их сургуулийг зоотехник, мал эмнэлэг, Хүн эмнэлэг, багш нарын 3 салбар, 90 гаруй оюутантай нээж, 1946 онд анхны төгсөлтөө хийжээ. МУИС богино хугацаанд зохион байгуулалт, материаллаг баазын талаар бэхэжсэн. 1957 оны байдлаар Монгол улсын их сургуульд түүх, эдийн засаг, монгол хэл уран зохиол, гадаад хэлний салбар бүхий нийгмийн ухааны факультет, мал эмнэлэг, зоо техник, агрономийн салбар бүхий хөдөөдаж ахуйн факультет, математик, физик хими, биологи, газар зүйн салбар бүхий байгалийн ухааны факультет, төрөл бүрийн нарийн мэргэжлийн эмч бэлтгэх анагаах ухааны факультет-нийт 39 тэнхим, 2500 гаруй оюутантай болсон байв. МУИС улс ардын аж ахуй, соёлын салбарт шаардлагатай төрөл бүрийн мэргэжилтэн бэлтгэх гол уурхай болж хувирчээ.”<sup>3</sup>

Ийнхүү Монгол улсын нийслэл Улаанбаатар хотод Улсын их сургууль байгуулагдсан нь монгол улсын хэмжээнд үндэсний дээд мэргэжилтэй боловсон хүчнийг өөрийн орондоо бэлтгэх үндэс суурь болсон юм. Анхны төгсөгчдөөс эхлээд монголын судлалын салбарт нэрээ дуурсгасан томоохон эрдэмтэд төрж гарч, бүтээл туурвил нь монгол улс төдийгүй дэлхийн монголч эрдэмтдийн дунд зохих байр сууриа эзэлснийг монголч эрдэмтэд мэднэ. Жишээ нь, байгуулагдах үеэс багшилсан Б. Ринчен, Ц. Дамдинсүрэн, Ш. Лувсанвандан нар монгол хэл, түүхийн салбарын оюутнуудад хичээл зааж, гол гол бүтээлээ туурвисан билээ.

Монгол улсын их сургууль зөвхөн өөрийн орны эрдэмтдийг бэлтгэхэд төдийгүй, гадаадын монголч эрдэмтдийг бэлтгэхэд ихээхэн хувь нэмэр оруулсан. 1950-аад оны сүүл үеэс монгол хэл, бичиг сурч монголын судлалаар мэргэших хүсэлтэй гадаадын оюутан, мэргэжил дээшлүүлэгч нар ирэх болсон бөгөөд одоо гадаадын монголын судлалын салбарт ажиллаж байгаа ахмад, дунд, залуу үеийнхний ихэнх нь энд суралцсан тэдгээр оюутан залуус юм. МУИС-д гадаадын оюутан суралцах болсон цагаас тэр цагаас эхлэн, гадаад хүнд монгол хэлийг заах арга зүй бий болж, мэргэжсэн багш нар буй болж, гадаад хүн монгол хэл сурах бичгийг тухай тухайн орны хүмүүст зориулан зохион хэвлүүлж ирсэн нь дотоод гадаадын их дээд сургуульд монгол хэл заах гол гарын авлага болсоор байна. 1980-аад оноос хойш гадаад орны монголын судлалын мэргэжилтнүүд МУИС-д мэргэжил дээшлүүлж, магистрантур, аспирантур, докторантурт суралцаж тухай тухайн чиглэлээр эрдмийн зэрэг хамгаалах нь жил ирэх бүр нэмэгдэж байгаа

3. Монгол улсын түүх, V боть (XX зуун), Улаанбаатар, 2003, 374-р тал.

### Ш.Чоймаа

нь монголын судлалын өргөжин тэлж буй нэг үзүүлэлт гэж хэлж болно.

Тус их сургуулийн эрдэмтэн багш нар өөр өөрсдийн чиглэлээр гадаадын монголч эрдэмтэдтэй хамтран ажиллаж ирсэн баялаг туршлагатай болсныг дурдах ёстой. Энэ нь 1950-аад оны сүүлчээс одоо хүртэл үргэлжилж, гадаадын их дээд сургуулиудын монголын судлалын салбарт зочин профессороор ажиллаж, тэдгээр орныхоо монгол судлаачийг бэлтгэхэд байнга тусалж ирсэн түүхтэй. Жишээлбэл, 1950-аад оны төгсгөл, 1960-аад оны эхээр монголын нэрт эрдэмтэн академич Ш. Лувсанвандан Бээжингийн их сургуульд ажиллаж, “Орчин цагийн монгол хэл” бүтээлээ тэнд хэвлүүлсэн билээ.

МУИС дахь Монголын судлалын уламжлал өнөөдөр ч тасралгүй явж буй. МУИС-ийн захирлын 2000 оны 11-р сарын 14-ны өдрийн 640 тоот тушаалаар монгол судлалыг бодлого чиглэлтэйгээр өргөжүүлэн хөгжүүлэх зорилгоор Монгол улсын их сургуулийн дэргэд Монгол судлалын төв байгуулагдаж, үйл ажиллагаагаа явуулж байв. Үүнийг 2011 онд МУИС-ийн Монгол судлалын хүрээлэн болгоод байна. Энэ онд 70 жилийнхээ ойг тэмдэглэж байгаа Монгол улсын ууган их сургууль маань цаашид ч монгол судлалыг тэргүүн зэрэгт үзэж, холбогдох үйл хэргийг дэмжиж, сургалт, судалгааг улам сайжруулах тухайд анхаарна гэдэгт итгэж байна.

Одоо дээр өгүүлсэн бүхэнд тулгуурлан түүхэн явцыг ололт амжилтын тустай хийгээд дутагдал бэрхшээлийн саадтай талыг нэгтгэн үзье.

Эдүгээ социализмын үе хэмээн нэрлэх болсон 1980-аад оны төгсгөл хүртэлх он жилүүдийг нэгтгэн үзвээс, монголын шинжлэх ухааны байгууллага, их дээд сургуулиуд нь тухайн үеийн бараг бүх социалист оронтой хамтран ажиллаж, хамтарсан судалгааг явуулж байсны дотор монголын судлалын чиглэл гол байрыг эзэлж байсан. Гэвч энэ үед коммунизмын үзэл суртал нарийн чанга байснаас социалист бус орнуудын монгол судлаач эрдэмтдийн бүтээлийг олж үзэж чадахгүй, олж үзсэн ч шууд эшлэн ашиглаж чадахгүй байсан нэгэн талын доголдлыг бас үнэнээр хэлэх ёстой. Ялангуяа олон зууны баялаг түүхтэй монголчуудын түүхийн ул мөрийг эргэн судлах үед зөвхөн нэг талыг барьсан үзэл суртлаар хэмжиж, монголын түүхийн өнгөрсөн үеийг бүхэлд нь үгүйсгэх, мэдлэг ухааны олон салбарыг багтаасан олон зууны бичгийн их өвийг феодализмийн, шашны, хоцрогдсон үзэл санаа агуулсан хэмээн унших судлахыг хориглох зэрэг хандлага түгээмэл байсан юм. Хэдий тийм боловч, түүх, археологи, угсаагны зүй, нутгийн аялгуу, аман зохиолын чиглэлээр удаа дараа эрдэм шинжилгээний анги явуулж, судалгааны эх хэрэглэгдэхүүнийг цуглуулж, тусгай сан бүрдүүлж, тэдгээрийг судалсан олон арван бүтээл гарсан ба мөн газарзүй, цаг уур, ургамал, ан амьтан, бэлчээр, газар тариалан, мал аж ахуй зэрэг улс ардын аж ахуйн олон салбараар судалгаа шинжилгээний бүтээлүүд гарчээ. Өөрөөр хэлбэл, Монгол улсын Монголын судлал олон чиг хандлагатай болж, тухай тухайн чиглэлээр судалгаа шинжилгээ хийх үндэсний монголч эрдэмтдийг бэлтгэж чадсан юм.

1980-аад оны төгсгөлөөс өнөөдөр хүртэлх хугацаанд Монгол улсын монгол судлалд томоохон өөрчлөлтийг авч үзвэл,

1. Үзэл суртлын хатуу хязгаар үгүй болж, судлаач хүн аль ч сэдвээр бүтээлээ туурвих боломжтой болжээ. Үүний үр дүнд монголын эртний үеийн түүх, хэл, уран зохиол, соёл, шашин шүтлэгийн хамаа бүхий чиглэлээр судалгааны бүтээлүүд олноор гарах болов.

2. Эх бичиг, сурвалжийн судалгаа шинэ шатанд гарч монгол бичиг, тод бичгээр байгаа дурсгал төвд, манж хэлээрх олон сурвалжийг шинжлэх ухааны үндэстэй судалж, олны хүртээл болгожээ. тухайлбал, 2011 онд МУИС-ийн эрдэмтэн багш нарын хэвлүүлсэн “XVII зууны монгол түүхэн сурвалжийн тулгуур эхүүд” хэмээх 5 боть цогц судалгааг нэрлэж болно.

3. Монголчуудын олон зууны зүйл зүйлийн мэдлэг ухааны өвийг тээж ирсэн монгол

### Ш.Чоймаа

бичгээ шамдан сурч, сургаж, улмаар XIII зуунаас XX зууны эхний хагас хүртэлх бичгийн их сан хөмрөгөө чөлөөтэй үзэж судлах болов. Мөн монголын судлалын суурь судалгаанд нэвтрэх гол гол түлхүүр болсон төвд, манж, тод, дөрвөлжин зэрэг үсэг бичгээр туурвисан дурсгалуудыг судлах талаар ихээхэн амжилт олов.

4. Монгол улсын монгол судлаачид гадаадын монголч эрдэмтдийн бүтээлийг бүрэн ашиглах, тэдэнтэй хамтран ажиллах талаар бэрхшээлгүй болсон билээ. Үүний дотор Монгол, Хятад улсын харилцаа эрс сайжирч, олон талаар хамтран ажиллах болсон нь монгол монголч эрдэмтэд тал талын тус дэмтэй хэрэг болсон. Энд онцлох нэг зүйл бол, Монголд болон дэлхийн улс оронд хадгалагдаж, үзэл суртлын эрхээр хаалттай байсан олон баримт хэрэглэгдэхүүнийг судалгааны эргэлтэд оруулах боломж нээгдсэн нь чухамхүү завшаантай хэрэг байв. Түүнчлэн гадаадын аль ч орны монголч эрдэмтэд Монгол улсад ирж, хүссэн чиглэлээрээ судалгааны хэрэглэгдэхүүн цуглуулах, монголын судлаачидтай чөлөөтэй хамтран ажиллах бололцоотой болсон нь эрхэм ололт, сайхан боломж юм.

5. Археологийн судалгааны салбарт олон орны эрдэмтэд, судалгааны багтай хамтран ажиллах болж, урьд хожидоос үлэмж илүү олз омогтой, шинэ шинэ нээлт ололт буй болж байна.

6. Монголын түүх, соёл, мэдлэг ухааны салбарт алдар нь түгсэн эрдэмтэн мэргэд, хутагт хувилгаадын ойг тэмдэглэх хүрээнд олон улсын эрдэм шинжилгээний хурал зохион байгуулах, тэдний зохиол бүтээлийг олны хүртээл болгох, тэр дундаа намтар судлалын чиглэлийг түлхүү хөгжүүлэх зэргээр олон шинэлэг ажил өрнөх болов.

7. Орчин үеийн техник, технологийн хөгжлийг дагалдан Монгол улсад программ хангамж, элетроник, мэдээллийн технологийн салбар эрчимтэй хөгжиж буй нь монгол судлалын үйл хэрэгт олон талаар сайхан боломж олгож байна.

8. Монгол улсын рюутнаас эхлэн эрдэмтэд хүртэл, гадаадын олон оронд суралцаж, эрдмийг зэрэг хамгаалж, мэргэжлээ дээшлүүлж, хамтран төсөл хэрэгжүүлэх болсон нь яах аргагүй том алхам байв.

Энэ мэтээр өгүүлбэл, ардчилсан өөрчлөлтийн үеийн 20 гаруй жилд аятай таатай нөхцөл, шинэ чиг хандлага олон гарчээ. Ерөнхийд нь авч үзвэл, "Монгол судлал" монгол орондоо хөгжин дэвжиж, цар хүрээ нь улам өргөжиж, судалгааны боломж нөхцөл сайжирсан. Гэвч жинхэнэ монгол ахуйд өсч хүмүүжсэн, авьяас билигтэй, монгол судлалд чин сэтгэлээ зориулсан залуу үеийн залгамж халаа их дутагдаж байна. Бас монгол судлалын эх хэрэглэгдэхүүн даяаршил, зах зээлийн хүрээнд устаж, үгүй болох нь улам бүр ихсэж байна.

II. Сүүлийн хэсгээс улбаалан Монголын судлалын цаашдын чиг хандлагад анхаарууштай болууштай зарим зүйлийн талаар товчхон дурдахыг зөвшөөрнө үү.

Монгол улсын тухайд, монгол судлаачдын гол зорилго нь монголчуудын эрт, одоо, ирээдүйг хамарсан, олон талыг багтаасан, чанар чансаатай судалгаагаа хийх ёстой гэдэг бол мэдээж хэрэг. Тэр дундаа амин чухал зүйл бол судалгаа хойч үе, хожмын монголын үр садал үр өгөөжөө өгөх ёстой. Үр өгөөж гэдэгтээ, даяаршлын давалгаан дунд монгол үндэстэн оршин байж, өөрийн хэл, соёл, түүх, ёс заншлаа хадгалан хамгаалахад чиглэсэн үйл ажлыг ойлгож байна. Гэтэл үзэж мэдсэнээ өөрийн бодлоор тайлбарлах нь тухайн хүний эрх боловч, сэдвээ гүйцэд мөшгиж судлахгүйгээр, хэвлэн нийтлэхийг урьдал болгох хандлага сүүл үед нэлээд газар авч, уншигч, сонсогчийг төөрөгдүүлэх тал байгааг хянамгай анхаарах цаг ирсэн. Өөрөөр хэлбэл, монгол судлал нь шинжлэлийн хувьд үнэн баримтал үндэслэсэн байхын сацуу, монголоо

### Ш.Чоймаа

хэмээх үндэсний мэдрэмжийг монгол иргэнд суулгах явдлыг мартах учиргүй. Эс тэгвээс, жинхэнэ монгол хүнгүй монголын судлалын оршихуй цаг ирэхийг төсөөлж ч эс зүрхэлнэ. Тэгэхлээр, Монгол улсын монголч эрдэмтдийн эрхэм үүргийг “монгол”-оо мэддэг монгол хүн төлөвшүүлэх гэж хэлж болох юм. Үүний дүнд, дэлхийд монголыг таниулсан нүүдлийн соёл иргэншлийг унаган төрхөөр нь хадгалж үлдэх, монгол хэл, соёлоороо судлагдах, ирээдүйгээ ч бэлтгэх боломжтой буюу “ийм байсан” гэж хэлж бичих бус, “энэ байна, ийм байдаг” хэмээн үзүүлж таниулах юмтай үлдэнэ гэсэн үг.

Ийм судалгааны тулд, байгалийн ухааны мэргэжилтэн, судлаач нар туршилтын лабораторид ажиллахгүйгээр амжилт олдоггүйтэй адил нийгэм, хүмүүнлэгийн ухааны монголч эрдэмтэн, судлаач нар судалгааны эх бичгээ, сурвалжаа ойлгож шинжилж чаддаг, бас хийсэн судалгааг бүрэн ашиглаж чаддаг байж үр дүнд хүрнэ. Эх бичгийн судалгааг товчоор тодорхойлоход, бичгээр болон амаар өвлөгдсөн үг хэллэг бүрийг үнэн зөв тайлан, үгийн бүтэц, үгийн сан, утгазүйн зөв тайлбар хийх явдал юм. Сурвалжаа ашиглах тэрхүү чадварыг эзэмшихийн тулд XIII зуунаас XX зууны эхний хагас хүртэлх монгол бичгийн дурсгалыг цуваа цагийн явцад нь зөв уншиж ухаж сурах хэрэгтэй. Энэ наад захын шат монгол бичгийн боловсролоос эхэлдгийг хэлүүлэх юун. Аман зохиолын далай баян санд эх бичгийн судалгаа хийхийн тулд түүхэнд үгийн сан, монголын олон нутгийн хэл аялгуу, ёс заншил зэргийг сайн мэдэх ёстой. Судлаачид мэдэхгүй үгээ юун түрүүнд ямар нэг толь бичгээс эрдэг. Гэвч энэхүү анхдагч лавлагаагаар ханаж болохгүй. Хэд хэдэн толь бичиг давхар лавлаж, бас уг судалж буй бүтээлтэйгээ ойр үеийн өөр эхэд тухайн үг хэллэг ямар утгаар тохиолдож байгааг хам эсдвээс эрж байж утгыг тогтоох, хэлний зүй тогтлоор үгийн бүтэц ямар болох, олон зуун жилд, нутгийн аялгуу болон авиан зүйн хувьслыг тусгасан онцлог байгаа, эсэхийг тогтоож шинжлэх гэх мэтээр үндсэндээ, ацаг шүдний зөрөөнөөс эхлэн тал талаас бодож, харьцуулж байж эх бичгийн судалгаа хийдэг. Энэ мэтийг өгүүлдэхийн учир бол эргээс эдүгээ хүртэлх үе үеийн монгол хэлний үг хэллэг бүрийн цаана монголын язгуур ухаан хадгалагдаж байдаг билээ.

Талархалтай нь, өнөөгийн байдлаар, XIII зуунаас XVIII зуун хүртэлх гол гол сурвалж, дурсгалын эх бичгийн судалгаа үндсэндээ хийгджээ. Харин ийм давуу тал байхад, залуу монголч нар цөлбөн нухах талаар хангалтгүй байгааг хэлэх ёстой. Тийм учраас манай монголч эрдэмтдээс гарын дор байх хэрэглэгдэхүүнээр “орчин цагийн” гэх тодотголтой судалгаа олноор гарч байна. Гэвч харамсалтайгаар, “орчин цагийн” эхлэл болсон өнгөрсөн үеийн хэрэглэгдэхүүнтэй холбон үзээгүй, монголчуудын хэл сэтгэлгээний онцлогийг, монгол үг хэллэг бүрийг түүхэн орчинд нь, тухайн цаг үед нь харгалзуулан танин мэдэхгүйгээр хийх дутагдал олонтоо ажиглагдаж байна. Цас хайлж, цаг үе чөлөөтэй болсон өнөө цагт урагш холбогдох хэдэн зууны сурвалжийн ч, судалгааны ч зүйлийг зайлшгүй үзэх шаардлагатай. Ингэж байж, тодорхойгоор үгүйлэгдэж буй үнэнд ойртсон судалгаа гарна гэдгийг эцэст нь тэмдэглэн хэлье.